

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код:13.020.01

Ашигт малтмалыг нуруулдан болон овоолон уусгах үйлдвэрийн хаалт. Ерөнхий шаардлага	MNS 6297 : 2011
Environment. Closure of heap and dump leaching facilities. General requirement	

Стандарчиллын Үндэсний Зөвлөлийн 2011 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 71 дүгээр тогтоолоор батлав.

Энэхүү стандартыг улсын бүртгэлд бүртгэсэн өдрөөс эхлэн мөрдөнө.

Энэ стандартын шаардлагыг заавал мөрдөнө.

1. Зорилго

Энэхүү стандартын зорилго нь ашигт малтмалыг нуруулдан болон овоолон уусгах технологи ашиглаж байгаа үйлдвэрийг хаах үед уурхайн үүсмэл орчин, орон зайн бүрдлийг аюулгүй болгох, эвдэрсэн газрыг нөхөн сэргээх, дэд бүтэц, барилга байгууламжийг ашиглах, хүрээлэн байгаа орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад оршино.

2. Хамрах хүрээ

Энэхүү стандарт нь ашигт малтмалыг нуруулдан болон овоолон уусгах аргаар олборлож буй уурхайн хаалт, нөхөн сэргээлтийн үйл ажиллагааны хүрээг хамаарна. Энэ стандартаар газрын доор уусган баяжуулах үйлдвэрийн хаалтын үйл ажиллагаа зохицуулагдахгүй.

3. Норматив эшлэл

Дараах эшлэл материалыг энэхүү стандартын лавлагаа болгон ашиглана. Он заагдсан эшлэлд зөвхөн заагдсан хувилбарыг ашиглана. Он заагдаагүй эшлэлд хамгийн сүүлийн хувилбарыг (бусад нэмэлтийг оруулан) ашиглана. Үүнд:

- Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Нэр томъёо, тодорхойлолт MNS 5914:2008
- Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын ангилал MNS 5915:2008
- Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт, хадгалалт MNS 5916:2008
- Уул уурхайн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Техникийн ерөнхий шаардлага MNS 5917:2008
- Эвдэрсэн газрыг ургамалжуулах. Техникийн ерөнхий шаардлага MNS 5918:2008
- Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS 0900:2005
- Усны чанар. Хаягдал бохир ус MNS 4943:2011
- Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага MNS 4586:1998
- Байгаль орчны хамгаалал. Усан мандал. Гадаргуугийн ба газрын доорхи усыг эрдэс бордооны бохирдлоос хамгаалах ерөнхий шаардлага MNS 3597:1983
- Байгаль орчны хамгаалал, усан мандал Газрын доорх усыг бохирдохоос хамгаалах ерөнхий шаардлага MNS 3342:1982
- Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ. Техникийн ерөнхий шаардлага MNS 5885:2008
- Байгаль хамгаалал. Хөрс. Хот, суурин газрын хөрсний ариун цэврийн үнэлгээний үзүүлэлтийн норм, хэмжээ MNS 3297:1991

MNS 6297 : 2011

- Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 5850:2008

4. Нэр томъёо, тодорхойлолт

Овоолгын уусгалт

Уурхайгаас гарсан хүдрийн овоолго дээрх бороожуулагчийн тусламжтайгаар уусгагч уусмалыг овоолгын дээд хэсгээс доош нэвчүүлэн металлыг уусгаж ялган авахыг ;

Нуруулдан уусгалт

Хүдрийг тодорхой бүхэллэгтэй болгон буталж уусгагчаар норгож, тусгайлан зассан уусмал үл нэвтрэх ёроолтой талбайд нуруулдаж металлыг уусган ялгаж авах аргыг;

Хаягдал

Ашигт малтмалын олборлолт, баяжуулалт, боловсруулалтын явцад гарсан эдийн засгийн хувьд ашиггүй эрдсийн агуулга бүхий үлдэгдлийг;

Хаягдлын хураагуур

Байгалийн болон хүний гараар байгуулсан хаалтаар хүрээлж, хуримтлуулсан ус, шаварлаг материал болон хатуу бодисыг төвлөрүүлэх байгууламжийг.

5. Техникийн шаардлага

5.1 Ерөнхий шаардлага

5.1.1 Ашигт малтмалыг нуруулдан уусгах үйлдвэрийн хаалтын төслийг уг аргыг хэрэглэж олборлодог ашигт малтмалын төрөл, орд тус бүрээр нь нарийвчлан хийнэ.

5.1.2 Химийн хорт бодисын хүлцэх стандарт агууламжийг тооцон саармагжуулах явцад хөрс, ус, агаарын бохирдлыг арилгаж, ургамал ургах, хүн, мал амьтан аюулгүй амьдрах орчин нөхцлийг бүрдүүлнэ.

5.2 Агаар

5.2.1 Хорт бодисыг саармагжуулан, хорт бодисын ууршилтыг зогсоож, сайтар битүүмжилж, хорт хийг агаарт дэгдэхээргүй нөхцлийг бүрдүүлсэн байна.

5.2.2 Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд ашиглагдсан химийн бодисууд нь өөр төрлийн химийн элементүүдтэй нэгдэж урвалд орохгүй байх нөхцлийг хангасан байна.

5.2.3 Химийн бодисын агуулах, уусмал бэлдэх цех, үйлдвэрийн цех, дамжлагын шугам хоолой, хаягдлын хураагуур орчмын агаар MNS 5885:2008 стандартын шаардлагыг хангасан байна.

5.3 Гадаргын болон гүний ус

5.3.1 Нуруулдсан болон овоолсон ядуу хүдрээс шүүрэн гарах шүүрэн гарах уусмалын рН=6-8 түвшинд / тухайн үйлдвэрийн хаалтын төслийн дагуу/ хүрсэн байна.

5.3.2 Гадаргын болон гүний ус бохирдохгүй байх нөхцлийг бүрэн хангасан, хамгаалалтын далан болон байгууламж бий болгосон байна.

5.3.3 Хаягдал ус нь MNS 4943:2011, MNS 3597:1983, MNS 6148:2010 стандартуудын шаардлагыг хангасан байна.

5.3.4 Нуруулдсан болон овоолсон ядуу хүдрийн овоолгын өндөржилт багатай хэсэгт буюу газрын гадаргын болон гүний усны урсацын чиглэлд /шаардлагатай цэгүүдэд/ хяналтын цооног өрөмдөж, хяналт хийх нөхцөл бололцоогоор хангасан байна.

5.4 Хөрс

5.4.1 Дэд бүтцийн барилга байгууламжуудаас орон нутаг болон аж ахуйн нэгж байгууллагад хүлээлгэн өгөх зайлшгүй шаардлагатай барилга байгууламжуудийг холбогдох хууль тогтоомжийн дагуу шилжүүлэн өгч орчны тохижилт, ургамалжуулалтын ажлыг стандартын дагуу бүрэн хийсэн байна.

5.4.2 Үйлдвэрлэлийн эдэлбэр газрыг бүрэн чөлөөлж, MNS 5918:2008 стандартын дагуу нөхөн сэргээнэ.

5.4.3 Нөхөн сэргээсэн газар орчин нь MNS 5916:2008, MNS 5918:2008, MNS 3297:1991 стандартуудын шаардлагыг хангасан байна.

5.5 Үйлдвэрийн талбай

Үйлдвэрийн талбай орчмын барилга байгууламж байсан газрын гадаргууг нөхөн сэргээж, байгалийн унаган төрхөнд ойртуулан шаардлагатай гидротехникийн болон үер уснаас хамгаалах байгууламжийг барьж байгуулсан байна.

5.6 Хүдрийн овоолго

5.6.1 Нуруулдсан болон овоолсон хүдрийн овоолго дахь уусмалыг зөвшөөрөгдөх хэмжээнд хүртэл саармагжуулан, MNS 5918:2008 стандартын дагуу нөхөн сэргээж ургамалжуулна.

5.6.2 Хүдрийн овоолгыг газрын гадаргуугийн усны нөлөөнд өртөхөөргүй байлгаж, тогтворжилтыг хангана. Гүний усанд нөлөөлөхгүй байх, шаардлагатай үед нэмэлт саармагжуулалт хийх нөхцлийг бүрэн хангасан байна.

5.7 Химийн хорт бодисын саармагжуулалт

5.7.1 Нуруулдан болон овоолон уусгах үйлдвэрийн үйл ажиллагаа дууссаны дараа хүхрийн хүчил, цианид болон бусад химийн хортой хольцын агуулах, уусмал бэлтгэж байсан хэсэг цех, үйлдвэрлэл явуулж байсан үйлдвэрийн цех, дамжлага, шугам хоолой, сав суулга, баглаа боодол зэргийн орчинд / агаар, ус, хөрсөнд/ дээрх элементүүд байгаа эсэх талаар төсөл хэрэгжүүлэгч аж ахуй нэгжийн зардлаар хөндлөнгийн мэргэжлийн байгууллагаар шинжилгээ хийлгэж, химийн бодистой холбоотой ноцтой эрсдэл байгаа эсэхэд дүгнэлт гаргуулна. Тус шинжилгээний дүгнэлтээр зөвшөөрөгдөх хэмжээнээс давсан бохирдол илэрсэн тохиолдолд түүнийг саармагжуулах арга хэмжээг авсан байна.

5.7.2 Стандартын 5.7.1 дэх заалтыг хэрэгжүүлэх арга хэмжээг Химийн хорт болон аюултай бодисын бодлого зохицуулалтын асуудал эрхэлсэн үндэсний зөвлөлийн хяналтын дор гүйцэтгэн дүгнэлт гаргуулна.

5.7.3 Төсөл хэрэгжүүлж эхлэхийн өмнө хаягдлын хураагуурыг тусгай зураг төслийн дагуу байгуулж ашигласан байна.

5.7.4 Хаягдлын хураагуур нь удаан хугацааны туршид тогтвортой, бүрэн битүүмжлэгдсэн байх нөхцлийг хангасан байна.

5.7.5 Хаягдлын саармагжуулалтыг зөвшөөрөгдөх хэмжээнд хүртэл Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээнд зааснаар химийн хортой болон аюултай бодис хадгалах, ашиглах, устгах үйл ажиллагааны холбогдох журмын дагуу зохион байгуулна.

5.7.6 Химийн хорт болон аюултай бодисын хадгалалт, ашиглалтанд хэрэглэгдэж байсан тоног, төхөөрөмж, багаж хэрэгсэл зэргийг саармагжуулж, акт үйлдэн зөвшөөрөгдсөн цэгт устгал хийнэ.

5.7.7 Хаягдал усыг саармагжуулан тодорхой хэрэглээнд ашиглах боломжийг бүрдүүлнэ.

5.8 Хяналт, шинжилгээ

MNS 6297 : 2011

5.8.1 Нөхөн сэргээлт хийсэн талбайн экосистемийн байгаль, нийгмийн үнэ цэнийг тогтоох, амьтан, ургамал, хөрсний үржил шимийн тогтворжилт, ус, хөрсний бохирдлыг хянах байнгын ажиглалт, судалгааг тухайн уурхайн цар хүрээ, нөөцийн хэмжээнээс нь хамааруулан хугацаа тогтоон хэрэгжүүлэх ба уг хугацаа нь 3-5 жилээс багагүй байна. Ажиглалт судалгааны үргэлжлэх хугацааны туршид гарах зардлыг нөхөн сэргээлт, хаалтын төслөөр тогтооно.

5.8.2 Үйлдвэрлэлийн хаалтын төсөлд уул уурхайн ашиглалт, баяжуулалт, үйлдвэрийн экологи, гидрогеологи, агробиологич зэрэг мэргэжлийн төлөөллийг оролцуулсан эрх бүхий шинжээчдийн багийн дүгнэлт гаргуулна.

5.9 Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүлээлгэн өгөх бичиг баримт

5.9.1. Үйлдвэрийн уулын ажлын байдлын маркшейдрийн хэмжилтийн зураг, анх батлагдсан геологийн нөөцийн дэвсгэр зураг бүхий нөөц ашиглалтын баталгаажсан тайлан, үйлдвэрийн хаалтын тухай акт, үлдэгдэл нөөц, нөөц өсгөх боломж, уурхайн хаалтын шалтгаан зэргийг нарийвчлан тусгасан протоколын хамт Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын нэгдсэн фондод хүлээлгэн өгнө.

5.9.2. Үйлдвэрийн хаалтын үйл ажиллагаатай холбогдуулан дараах материалыг хүлээлгэн өгнө. Үүнд:

- Уулын ажлын үндсэн планшейтүүд
- Уурхайн уулын ажлын нэгдсэн зураг
- Ордын тогтоогдсон нөөцийн үлдэгдэл түүний дотор нийт, бэлтгэгдсэн, олборлох шаардлагатай байсан нөөцийг тооцоолсон магадлагаа
- Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв, орон нутгийн байгууллагын орчны бохирдолт, нөхөн сэргээлт хийсэн тухай тодорхойлолт
- Уулын малтмалт, овоолго, тэдгээрийн байршил, хэмжээ бүхий байр зүйн зураг.

5.10 Хүний нөөц, хөгжлийн асуудал

5.10.1. Хүний нөөц, ажиллах хүч, боловсон хүчний асуудлыг урьдаас төлөвлөн ажилгүйдэл, хот суурин эзэнгүйдэх асуудлыг эерэгээр шийдэх арга хэмжээг авч үндсэн ажилтнуудыг ажлын байраар хангах нөхцлийг бүрдүүлж хэрэгжүүлсэн байна.

5.11 Хаалтын зардал

5.11.1 Ашигт малтмалыг ашиглах тусгай зөвшөөрөл эзэмшигч нь үйлдвэрийн хаалт, хяналт шинжилгээний ажлын зардлыг бүрэн хариуцна.

ТӨГСӨВ.